

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ  
ДАРГА



О.БАТТУЛГА

## МОНГОЛЫН ХҮҮХДИЙН СПОРТЫН VII НААДМЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН СПОРТЫН ТӨРЛИЙН НЭГДСЭН ЗААВАР

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ын 2.1 дахь заалт, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2023 оны А/19 дугаар тушаалын 2.8 дахь хэсэгт заасан хэрэгжилтийг хангаж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын хөгжлийг дэмжих, тэднийг татан оролцуулах арга хэмжээг нэмэгдүүлэх, түүний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, авьяаслаг тамирчдыг нээн илрүүлэх, тив, дэлхийн тэмцээнд өрсөлдөх тамирчдыг төрүүлэн гаргахад энэхүү наадмын зорилго оршино.

Хөгжлийн бэрхшээлтэй тамирчин хүүхдүүдэд спортын ажил, үйлчилгээ үзүүлэх замаар дасгал хөдөлгөөн, спортоор хичээллэх сонирхлыг төрүүлэх, нийгэмд эерэг манлайллыг бий болгох, нийгмийн идэвхтэй оролцоог спортоор дамжуулан нээж өгөх, дадал, төлөвшлийг бий болгох;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын хороодтой хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлэх, нийгэмд зөв мэдээлэл, мэдлэг өгөх хандлагыг өөрчлөхөд чиглэх, хүүхдийн дунд зохиох бие бялдрын хүмүүжлийн ажил, спортын үйл ажиллагааг дэмжих, сургалт дасгалжуулалтын чанар, үр дүнг нэмэгдүүлэх, есвөрийн тамирчдын өрсөлдөх чадавхыг дээшлүүлэх

### ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Улсын хэмжээнд наадмын ерөнхий зохицуулалтыг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо ханган, наадмын хөтөлбөрт багтсан тэмцээн зохион байгуулж буй Спортын холбоо, хороодтой гэрээний дагуу хамтран ажиллах, санхүү, үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.

2.2 Биеийн тамир, спортын улсын хороо нь нэгдсэн зааврын хүрээнд ерөнхий зохион байгуулалтыг хариуцна.

2.3 Наадмын зохион байгуулах чиг үүргийг Биеийн тамир, спортын улсын хорооны асуудал хариуцсан нэгж, Монголын үндэсний паралимпын хороо болон холбоод, Диф спортын хороо, Монголын тусгай олимпын хороо, спортын холбоодтой хамтран зохион байгуулалтыг ханган ажиллана.

2.4 Наадмын хөтөлбөрт багтсан спортын төрлийн тэмцээнийг олон улсын спортын хороо, холбоодын гишүүнчлэлтэй спортын холбоодтой хамтран зохион байгуулна.

2.5 Наадамд аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга, Биеийн тамир, спортын газар, хороод, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургууль баг тамирчдаа бэлтгэн оролцуулах ба удирдлагаар хангана.

2.6 Наадамд оролцогчдын цахим бүртгэл, үр дүн, байгууллагын нэгдсэн дүн болон цахим хуудастай холбогдох бүхий л үйл ажиллагааг Биеийн тамир, спортын улсын хорооны мэдээллийн технологи хариуцсан нэгж хариуцна.

2.7 Наадмын явцын мэдээ, мэдээллийг Биеийн тамир, спортын улсын хороо, Монголын үндэсний паралимпын хороо болон холбоод, Диф спортын хороо, Монголын тусгай олимпын хороо, спортын холбоод нийтэд сурталчлан мэдээлж, түгээнэ.

2.8 Наадмын спортын төрлийн тэмцээнийг олон улсын дүрэм, спортын холбооны тэмцээний зааварт нийцүүлэн наадмын нэгдсэн заавартай зөрчилдөхгүй байна.

## ГУРАВ. СПОРТЫН ТӨРӨЛ

3.1 Спортын төрлийн тэмцээнийг дараах үе шаттайгаар зохион байгуулна.

Үүнд:

3.1.1 Анхан шат:

Аймаг, нийслэл, дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургууль, Биеийн тамир, спортын газар, хороо, Монголын үндэсний паралимпын хороо болон холбоо, Диф спортын хороо, Монголын тусгай олимпын хороодтой хамтран зохион байгуулна. /Анхан шатны тэмцээн зохион байгуулах шаардлагатай бол/

3.1.2 Шигшээ шат:

Биеийн тамир, спортын улсын хороо нь Монголын үндэсний паралимпын хороо болон холбоо, Диф спортын хороо, Монголын тусгай олимпын хороо болон наадмын хөтөлбөрт багтсан спортын төрлийн холбоотой хамтран зохион байгуулна.

## ДӨРӨВ. ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ХУГАЦАА, СПОРТЫН ТӨРӨЛ

4.1. Наадмыг дараах хугацаанд зохион байгуулна. Үүнд:

Анхан шатны тэмцээн: 2023 оны 09 дүгээр сарын 9-10-ны өдрүүдэд оролцогчийн тооноос хамаарч зохион байгуулна.

Шигшээ тэмцээн: 2023 оны 09 дүгээр сарын 15-20 өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдана. Нээлтийн арга хэмжээ 09 дугаар сарын 15-ны өдөр, хаалтын арга хэмжээ 09 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулагдана.

4.2. СПОРТЫН ТӨРЛҮҮД:

1. Паралимпын спортын төрөл: жүдо, хөнгөн атлетик, хонхтой бөмбөг, бочи
2. Дифлимп спортын төрөл: ширээний теннис, волейбол
3. Тусгай олимпын спортын төрөл: волейбол, бочи

#### 4.2.1 СПОРТЫН ТӨРЛҮҮДИЙН ЗАЙ, ЖИН, НАСНЫ АНГИЛАЛ

д/д	Спортын ангилал, төрөл		насны ангилал	Жин зай, ангилал		
				Хөвгүүд	Охид	ангилал
1	Тусгай	волейбол	13-17 нас 2006.01.01 2012.12.31	баг-8хүнтэй, (дэмжин тоглогч-2)	баг-8 хүнтэй (дэмжин тоглогч-2)	
2		бочи	13-17 нас 2006.01.01 2012.12.31	ганцаарчилсан	Ганцаарчилсан	L1, L2
3	Пара	жүдо	12-17 нас 2006.01.01- 2011.12.31	- 55кг, -66кг, -73кг;	-44кг, -48кг, -57кг;	J1; J2
4		хөнгөн атлетик	12-17 нас 2006.01.01 2011.12.31	400м	200м	T11 бүтэн хараагүй /хөтлөгчтэй/
				400м	200м	T12,13; сул хараатай;
				200м	100м	T37,38: хөнгөн хэлбэрийн саажилттай;
				400м	400м	T46: гар тайралттай
				400м	400м	T53,54,55,56: тэргэнцэртэй уралдаан
				2кг-бөөрөнцөг	2кг-бөөрөнцөг	F57 хөлийн тайралттай;
		397 грамм модон саваа шидэлт;	397 грамм модон саваа шидэлт;	F32,33,34,51; хүнд хэлбэр саажилттай;		
5	хонхтой бөмбөг	12-17 нас 2006.01.01 2011.12.31	Баг -4 хүнтэй	Баг - 4 хүнтэй	хараагүй	
6	бочи	13-17 нас 2006.01.01 2012.12.31	Ганцаарчилсан	Ганцаарчилсан	BC-2	
7	Диф	ширээний теннис	15-17 нас 2006.01.01 2008.12.31	ганцаарчилсан	Ганцаарчилсан	55 дБ+
8		волейбол	15-17 нас. 2006.01.01 2008.12.31	баг 8 хүнтэй	баг- 8 хүнтэй	55 Б+

4.3 Техникийн зөвлөгөөн: Наадмын хөтөлбөрт багтсан спортын төрлийн тэмцээнийг зохион байгуулах тухайн спортын холбооны удирдлага, шүүгчийн зөвлөл хамтран тэмцээн болох өдрөөс 1-2 хоногийн өмнө тухайн тэмцээний техникийн зөвлөгөөнийг зарлан хуралдуулж, зохион байгуулна.

4.4 Тэмцээнийг хуваарийн дагуу зохион байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй тамирчны ангиллыг олон улсын дүрмийн дагуу тогтоох, спортын хувцас, хэрэглэл,

зохион байгуулалтай холбогдох бүхий л асуудлыг техникийн зөвлөгөөн дээр хэлэлцэн шийдвэрлэнэ.

4.5 Наадмын хөтөлбөрт багтсан спортын төрлийн тэмцээний заавар нь энэхүү нэгдсэн зааврын салшгүй хэсэг байна. Спортын холбоод нэгдсэн зааврын дагуу спортын төрөл дээр тэмцээний заавраа баталж гаргана.

#### ТАВ. ОРОЛЦОГЧДОД ТАВИХ ШААРДЛАГА

5.1 Наадамд оролцогч тамирчин нь нэг оролцогч, нэг бүртгэл гэсэн шаардлагыг хангасан байна.

5.2 Аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороод, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургууль нь өөрсдийн тамирчдын тэмцээнд оролцох бүртгэл, төрөл сонгох, оролцоо, аюулгүй байдал, тээвэрлэлт, дэмжлэг үзүүлэх ажлыг хариуцна.

5.3 Аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороод, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургууль нь тамирчны цахим гэрээ, мэдүүлгийн маягт илгээхээс өмнө үндсэн байгууллагын удирдлага, дасгалжуулагч, эцэг эх, асран хамгаалагч нартай харилцан зөвшилцөлд хүрсний дагуу дурдсан хугацаанд хүсэлтээ илгээнэ.

5.4 Наадамд оролцох багууд нь бэлтгэлийн хувцас, спортын төрлийн тоглолтын хувцас, байгууллагын нэр, логотой туг далбааг барьж жагсана. Тугийн хэмжээ нь 60 см х120 см хэмжээтэй байна.

#### ЗУРГАА. ЭМНЭЛЭГ ХЯНАЛТ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ДААТГАЛ

6.1 Наадамд оролцогч байгууллага өөрийн нэрийн өмнөөс оролцох баг тамирчдаа эрүүл мэндийн үзлэгт хамруулж, үзлэгийн “зөвшөөрсөн” тэмдэглэгээг эмчийн гарын үсэг, тамгаар баталгаажуулсан байна.

6.2 Тамирчдыг тэмцээний өдрүүдэд гэнэтийн ослын болон бусад холбогдох даатгалд харьяалах байгууллагын зүгээс зайлшгүй хамруулж даатгуулах үүрэг хүлээнэ.

6.3 Аюулгүй байдлыг хамгаалах хэрэглэл, хэрэгслийг тэмцээнд оролцох тамирчдад стандартын дагуу зориулалтаар хэрэглэхийг тамирчин, хариуцсан дасгалжуулагч, багийн ахлагчаас дүрмийн дагуу шаардана.

6.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын төрөл тус бүр дээр ангилал тогтоох нарийн мэргэжлийн эмчийн оношийг тогтоолгон харгалзах тухайн спортын нэг төрлийн жин, зайд тамирчныг тэмцээнд албан ёсоор оролцуулна.

6.5 Тэмцээн зохион байгуулагчийн аюулгүй ажиллагаа:

6.5.1 Тэмцээн зохион байгуулах тухайн спортын холбоо нь тамирчдын болон үзэгчдийн аюулгүй байдалд олон улсын дүрмийн шаардлагын дагуу бүрэн хяналт тавьж ажиллана.

6.5.2 Тэмцээний явцад зөрчил гаргасан тамирчин, дасгалжуулагчдад олон улсын дүрмийн дагуу шаардлага тавих, шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд зохион байгуулагч болон шүүгчийн зөвлөлөөс хариуцлага хүлээлгэнэ.

## ДОЛОО. ЦАХИМ БҮРТГЭЛ, ЯВАГДАХ ХУГАЦАА, МАНДАТ ОЛГОЛТ

7.1 Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороод, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургууль нь наадмын хөтөлбөрт багтсан спортын төрөлд оролцох тамирчны мэдүүлэг, хувь хүний мэдээллийг ашиглахыг зөвшөөрсөн цахим гэрээ, бүртгэлийг 2023 оны 09 дүгээр сарын 06 -ны өдрөөс 2023 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн хооронд ирүүлнэ. /Цахим мэдүүлэг ирүүлэх холбоосыг цахим шуудангаар хүргүүлнэ./

7.2 Аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороод тэмцээний талаарх цахим мэдээллийн санг бүрдүүлэн, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж ажиллана.

7.3 Шигшээ тэмцээнд оролцох баг тамирчдын нэрэн мэдүүлэг 2023 оны 09 дүгээр сарын 11-ны өдөр ирүүлэх.

7.3.1 Наадмын хөтөлбөрт багтсан тэмцээнд оролцох баг тамирчдын цахим гэрээ, нэрэн мэдүүлгийг үндэслэн Биеийн тамир, спортын нэгдсэн цахим сангийн бүртгэлээр дамжуулан мандат олгоно. Шигшээ тэмцээний цахим систем нь 2023 оны 09 дугаар сарын 06-ны өдөр нээж, 2023 оны 09 дугаар сарын 13-ны өдрийн 15:00 цагт хаана.

7.3.2 Бүртгэлд хамрагдсан баг тамирчдын QR кодтой мандатын эх файлыг харьяалах байгууллагын албаны цахим шуудангийн хаягаар илгээнэ.

7.4 Биеийн тамир, спортын улсын хорооны цахим бүртгэлийн асуудал хариуцсан нэгжээс баталсан цахим бүртгэлийн сургалтыг 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.

7.5 Биеийн тамир, спортын улсын хорооны цахим бүртгэлийн асуудал хариуцсан нэгж нь Боловсрол шинжлэх ухааны яамны асуудал хариуцсан нэгжээс сурагчийн мэдээллийн сүлжээний оролцоотойгоор нягтлан бүртгэлийн бүхий л үйл ажиллагааг хариуцаж ажиллана.

## НАЙМ.НААДМЫН ТӨСӨВ САНХҮҮЖИЛТ

8.1 Наадмын шигшээ тэмцээний хөтөлбөрт багтсан тэмцээнд оролцогч баг тамирчид зардлыг харьяалах байгууллага нь хариуцан санхүүжүүлнэ.

8.2 Баг тамирчдаас тэмцээний мандатын үнэ, бусад хураамж авахгүй.

8.3 Наадмын зохион байгуулалтын зардлыг Биеийн тамир, спортын улсын хороо хариуцна.

## ЕС. ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ, ХАРИУЦЛАГА

7.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын төрлийн шигшээ тэмцээний төрөл зай, ангилал тус бүрд медаль хүртэж байр эзэлсэн баг, тамирчин, дасгалжуулагчийг Монголын хүүхдийн спортын VII наадмын медаль, өргөмжлөл, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 173 дугаар тогтоолын дагуу мөнгөн шагналаар шагнана.

7.2 Тамирчны регистрийн дугаар, нас, овог нэрийг санаатай буюу буруу бөглөсөн, харьяаллын болон бусад зөрчил илэрсэн тохиолдолд тухайн тэмцээний амжилтыг хүчингүйд тооцон дараагийн эрэмбэлэгдсэн тамирчинд эзэлсэн байр, шагналыг шилжүүлнэ.

7.3 Монголын хүүхдийн спортын VII наадамд оролцогч байгууллагыг спортын төрлүүдэд авсан медалийн чанараар дүгнэж аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороод болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийг эхний 3 байр тус тус эзлүүлж цом, медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

## АРАВ.САХИЛГА БАТ, ДЭГ ЖУРАМ

10.1 Спортын үнэт зүйл болох мэндлэх, талархах ёс үйлдлийг баримтална. Спортоор дамжуулж тамирчдад сахилга бат, ёс зүйтэй байх, нийгэмд зөв хандлага, эерэг нөлөөллийг бий болгоно.

10.2 Баг тамирчид спортын наадмын үйл ажиллагаа, тэмцээний зам талбай гараа, бариа тогтсон байршилд, нэгдсэн зохион байгуулалтад орж үүрэг хариуцлага, хувь хүний харилцаа хандлагыг бүрэн ухамсарлаж хариуцна.

10.3 Өрсөлдөгч нараа хүндэтгэн, шударга өрсөлдөөнийг үзүүлнэ.

## АРВАН НЭГ. ХҮСЭЛТ ГОМДОЛ

11.1 Тэмцээнд оролцох баг тамирчид маргаантай асуудлаар тухайн төрлийн тэмцээний ерөнхий шүүгчид хүсэлт, гомдол гаргах эрхтэй. Спортын наадмын хөтөлбөрт багтсан спортын төрлийг зохион байгуулах спортын хороо, холбооны маргаан таслах зөвлөл шийдвэрлэнэ.

11.2 Хүсэлт, гомдлыг зөвхөн тухайн баг хариуцсан дасгалжуулагч, багийн ахлагч бичгээр өөрийн биеэр тэмцээний ерөнхий шүүгчид багийн нэр хаяг, гарын үсгийг тодорхой цаг хугацааг бичиж хандана. Шүүлттэй холбоотой маргааныг тэмцээний жин, зай төрөл дуусгавар болсноос 30 минутын дотор бичгээр хандсан байна.

11.3 Цахим бүртгэлтэй холбоотой гаргасан хүсэлт, гомдлыг Биеийн тамир, спортын улсын хорооны асуудал хариуцсан нэгжид гаргана.

## СПОРТЫН ТӨРЛИЙН ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР

### НЭГ.ТУСГАЙ ОЛИМПЫН СПОРТЫН ТӨРӨЛ

#### 1.1 ВОЛЕЙБОЛ:

**ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:** Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын наадамд оролцохоор цахим бүртгэлд бүртгэгдсэн 21 аймаг, 9 дүүрэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн тамирчид анхан шатны тэмцээний сонгон шалгаруулалтгүйгээр оролцох эрх авна.

**НАСНЫ АНГИЛАЛ:** 13-17 нас: 2006.01.01-2010.12.31

**ТӨРӨЛ:** Нэгдсэн зааврын 4.2.1 дэх заалтад заасан тухай спортын төрлийн жин, зай, ангиллын дагуу оролцоно.

Түвшин тогтоох сорил тэмцээнийг хийхгүй зөвхөн үндсэн болон дэмжин тоглогчдын хоорондын ур чадварын ялгаагүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын наадмын спортын төрөлд дараах эрүүл мэндийн онош /F70,F84,Q90,G80,G40,N11/ хамаарах эрх бүхий тамирчид бүртгүүлнэ.

**ТЭМЦЭЭН ЯВУУЛАХ ЖУРАМ:** Олон улсын Тусгай Олимпын спортын ерөнхий дүрэмд нийцүүлэн адил түвшний дэмжин 2 тоглогч тухайн спортын цол, зэрэггүй байна.

Монголын тусгай олимпын хорооноос томилогдсон шүүгчид тэмцээнийг шүүн явуулна Монголын тусгай олимпын хорооноос томилогдсон шүүгчид тэмцээнийг шүүн явуулна.

**ЯВАГДАХ ГАЗАР:** Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, СТО зааланд зохион явуулна.

**ХУГАЦАА:** 2023 оны 09-р сарын 18,19-ний өдрүүдэд зохион байгуулагдана.

#### 1.2 БОЧИ

**ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:** Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын наадамд оролцохоор цахим бүртгэлд бүртгэгдсэн 21 аймаг, 9 дүүрэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн тамирчид анхан шатны тэмцээний сонгон шалгаруулалтаас шалгарч оролцох эрх авна.

**НАСНЫ АНГИЛАЛ:** 13-17 нас: 2006.01.01-2010.12.31

**ТӨРӨЛ:** Нэгдсэн зааврын 4.2.1 дэх заалтад заасан тухай спортын төрлийн жин, зай, ангиллын дагуу оролцоно.

Анхан шатнаас шалгарсан нийслэлийн тусгай хэрэгцээт болон тэгш хамруулан сургах ерөнхий боловсролын сургуулиас эрэгтэй-8, эмэгтэй-8, аймаг, дүүргийн халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй суралцагч бус тамирчин эрэгтэй-3, эмэгтэй-3, оролцох эрхтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын наадамд дараах эрүүл мэндийн онош /F70,F84,Q90,G80,G40,N11/ хамаарах эрх бүхий тамирчид бүртгүүлнэ.

**ТЭМЦЭЭН ЯВУУЛАХ ЖУРАМ:** Олон улсын Тусгай Олимпын спортын ерөнхий дүрэм, үндэсний тусгай бочи дүрмийг дагаж мөрдөнө. Монголын тусгай олимпын хорооноос томилогдсон шүүгчид тэмцээнийг шүүн явуулна.

**ЯВАГДАХ ГАЗАР:** Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг. Биеийн тамир, спортын хорооны зааланд зохион явуулна.

**ХУГАЦАА:** 2023 оны 09-р сарын 16,17-ний өдрүүдэд зохион байгуулагдана.

## ХОЁР. ПАРАЛИМПИЙН СПОРТЫН ТӨРӨЛ

### 2.1 ЖУДО:

**ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:** Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын наадамд оролцохоор цахим бүртгэлд бүртгэгдсэн 21 аймаг, 9 дүүрэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн тамирчид анхан шатны тэмцээний сонгон шалгаруулалтгүйгээр оролцох эрх авна.

**НАСНЫ АНГИЛАЛ:** 12-17 нас. 2006.01.01-2011.12.31

**ТӨРӨЛ:** Нэгдсэн зааврын 4.2.1 дэх заалтад заасан тухай спортын төрлийн жин, зай, ангиллын дагуу оролцоно.

**ТЭМЦЭЭН ЯВУУЛАХ ЖУРАМ:** Монголын жүдо бөхийн холбооны шүүгчийн зөвлөлөөс томилогдсон Олон улсын болон улсын шүүгчид, спорт, техникийн IJF-ны дүрмийн дагуу удирдан явуулна. Жин тус бүрд 1 байгууллагаас оролцох тамирчдын тоог харгалзахгүй.

Тэмцээнд хараагүй болон харааны бэрхшээлтэй J1, J2 ангиллын тамирчид оролцоно. Нүдний хараа нь 50%-аас дээш, эмчийн бичигтэй, группийн дэвтэртэй ирнэ.

Тамирчин: Олон улсын дүрмийн дагуу цагаан, цэнхэр өнгийн жүдогитой барилдана.

Дасгалжуулагчид: бүрэн ёслолын хувцастай тамирчнаа дасгалжуулна.

**ЯВАГДАХ ГАЗАР:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг. Спортын төв ордонд зохион явуулна.

**ХУГАЦАА:** 2023 оны 09-р сарын 16-ны өдрүүдэд зохион байгуулагдана.

### 2.2 ХӨНГӨН АТЛЕТИК:

**ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:** Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын наадамд оролцохоор цахим бүртгэлд бүртгэгдсэн 21 аймаг, 9 дүүрэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн тамирчид анхан шатны тэмцээний сонгон шалгаруулалтгүйгээр оролцох эрх авна.

**НАСНЫ АНГИЛАЛ:** 12-17 нас. 2006.01.01-2012.11.31

**ТӨРӨЛ:** Нэгдсэн зааврын 4.2.1 дэх заалтад заасан тухай спортын төрлийн жин, зай, ангиллын дагуу оролцоно.



**ТЭМЦЭЭНИЙ ЯВУУЛАХ ЖУРАМ:** Тэмцээнийг Олон улсын пара хөнгөн атлетикийн холбооноос дагаж мөрдөж буй дүрэм, журмын дагуу Монголын үндэсний пара хөнгөн атлетикийн холбооноос батлагдсан шүүгчдийн бүрэлдэхүүн удирдан явуулна. Иж бүрэн хувцас, энгэрийн дугаартай байна.

**ЯВАГДАХ ГАЗАР:** Улаанбаатар хот, Налайх дүүрэг. Хөнгөн атлетикийн талбайд зохион явуулна.

**ХУГАЦАА:** 2023 оны 09-р сарын 16,17-ний өдрүүдэд зохион байгуулагдана.

### 2.3 ХОНХТОЙ БӨМБӨГ:

**ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:** Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын наадамд оролцохоор цахим бүртгэлд бүртгэгдсэн 21 аймаг, 9 дүүрэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн тамирчид анхан шатны тэмцээний сонгон шалгаруулалтгүйгээр оролцох эрх авна.

**НАСНЫ АНГИЛАЛ:** 12-17 нас. 2007.01.01-2012.12.31

**ТӨРӨЛ:** Нэгдсэн зааврын 4.2.1 дэх заалтад заасан тухай спортын төрлийн жин, зай, ангиллын дагуу оролцоно.

**ТЭМЦЭЭНИЙ ЯВУУЛАХ ЖУРАМ:** Монголын хонхтой бөмбөгийн холбооноос олон улсын тэмцээн зохион байгуулах дүрмийн дагуу явуулна. Тэмцээнд В2, В3 ангиллын 50% харааны бэрхшээлийн алдагдалтай тамирчид оролцоно. Тамирчид жигд хувцас, нүдний хаалт өвдөг, тохойн хамгаалалт, эмчийн магадалгаатай байх ба 10x20 хэмжээтэй 1-9 гэсэн хувийн дугаарыг хувцасны ар, өвөр талдаа байрлуулсан байна.

**ЯВАГДАХ ГАЗАР:** Улаанбаатар хот, Чингэлтэй, Хан-Уул дүүрэг. Биеийн тамир, спортын хорооны зааланд зохион явуулна.

**ХУГАЦАА:** 2023 оны 09-р сарын 16,17-ны өдрүүдэд зохион байгуулагдана.

### 2.4 БОЧИ:

**ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:** Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын наадамд оролцохоор цахим бүртгэлд бүртгэгдсэн 21 аймаг, 9 дүүрэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн тамирчид анхан шатны тэмцээний сонгон шалгаруулалтгүйгээр оролцох эрх авна.

**НАСНЫ АНГИЛАЛ:** 13-17 нас. 2007.01.01-2013.12.31

**ТӨРӨЛ:** Нэгдсэн зааврын 4.2.1 дэх заалтад заасан тухай спортын төрлийн жин, зай, ангиллын дагуу оролцоно.

**ТЭМЦЭЭН ЯВУУЛАХ ЖУРАМ:** Монголын пара бочигийн холбооны шүүгч нар, олон улсын пара бочигийн холбооны дүрмийн дагуу тусгай зориулалттай талбай дээр удирдан явуулна. Эмч шүүгч ажиллана.

**ЯВАГДАХ ГАЗАР:** Улаанбаатар хот, Баянгол дүүрэг. Ерөнхий боловсролын 70 дугаар сургуулийн биеийн тамирын зааланд зохион явуулна.

**ХУГАЦАА:** 2023 оны 09-р сарын 18,19-ний өдрүүдэд зохион байгуулагдана.

## ГУРАВ. ДИФ СПОРТЫН ТӨРӨЛ

### 3.1 ШИРЭЭНИЙ ТЕННИС:

**ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:** Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын наадамд оролцохоор цахим бүртгэлд бүртгэгдсэн 21 аймаг, 9 дүүрэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн тамирчид анхан шатны тэмцээний сонгон шалгаруулалтгүйгээр оролцох эрх авна.

**НАСНЫ АНГИЛАЛ:** 15-17 нас. 2007.01.01-2009.12.31

**ТӨРӨЛ:** Нэгдсэн зааврын 4.2.1 дэх заалтад заасан тухай спортын төрлийн жин, зай, ангиллын дагуу оролцоно.

**ТЭМЦЭЭНИЙ ЯВУУЛАХ ЖУРАМ:** Спортын төрөл олон улсын монголд мөрдөж буй дүрмээр, тэгэхдээ сонсголын бэрхшээлийн онцлогт таарсан арга шүүлтээр зохион байгуулна. Олон улсын диф спортын хорооноос баталсан диф спортын тэмцээний зохион байгуулалтын жишиг журмыг баримтална. Зохион байгуулах хороо шүүгчдийг томилно. Тэмцээнд 55dB PTA алдагдалтай тамирчид оролцоно.

**ЯВАГДАХ ГАЗАР:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг. Ерөнхий боловсролын 29 дугаар сургуулийн биеийн тамирын зааланд зохион явуулна.

**ХУГАЦАА:** 2023 оны 09-р сарын 16-ны өдрүүдэд зохион байгуулагдана.

### 3.2 ВОЛЕЙБОЛ:

**ЗОХИОН БАЙГУУЛАЛТ** Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын наадамд оролцохоор цахим бүртгэлд бүртгэгдсэн 21 аймаг, 9 дүүрэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн тамирчид анхан шатны тэмцээний сонгон шалгаруулалтгүйгээр оролцох эрх авна.

**НАСНЫ АНГИЛАЛ:** 15-17 нас. 2007.01.01-2009.12.31

**ТӨРӨЛ:** Нэгдсэн зааврын 4.2.1 дэх заалтад заасан тухай спортын төрлийн жин, зай, ангиллын дагуу оролцоно.

**ТЭМЦЭЭНИЙ ЯВУУЛАХ ЖУРАМ:** Спортын төрөл тус бүр олон улсын монголд мөрдөж буй дүрмээр, тэгэхдээ сонсголын бэрхшээлийн онцлогт таарсан арга шүүлтээр зохион байгуулна. Олон улсын дифлимп спортын хорооноос баталсан дифлимп спортын тэмцээний зохион байгуулалтын жишиг журмыг баримтална. Зохион байгуулах хороо шүүгчдийг томилно. Тэмцээнд 55dB+ PTA алдагдалтай тамирчид оролцоно.

**ЯВАГДАХ ГАЗАР:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг. Ерөнхий боловсролын 29 дугаар сургуулийн биеийн тамирын зааланд зохион явуулна.

**ХУГАЦАА:** 2023 оны 09-р сарын 17-ны өдрүүдэд зохион байгуулагдана.